



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 242

Улаанбаатар хот


Түр журам батлах тухай

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.5, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Журмыг хэрэгжүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл /Ж.Батсуурь/, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Цогтсайхан/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Э.Ганхүү/-т тус тус үүрэг болгосугай.



Б.МӨНХБААТАР

1559316364

ЦЭВЭР, БОХИР УСНЫ ХЭРЭГЛЭЭГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын дагуу айл өрхийн болон зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах /цаашид “төрөөс хариуцах төлбөр” гэх/ болсонтой холбогдуулан ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний найдвартай, тогтвортой ажиллагааг хангахад энэхүү түр журмыг мөрдөнө.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх/ болон айл өрх, дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага энэхүү түр журмыг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө. Үүнд:

- төсөвт байгууллага;
- төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд;
- уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр;
- банк, банк бус санхүүгийн байгууллага;
- криптовалюоттай холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- газрын тосны бүтээгдэхүүн, импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- интернет, үүрэн холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- өнгөт металл болон хар төмөрлөг, цементийн үйлдвэр.

2.2. Төрөөс хариуцах төлбөрт дор дурдсан цэвэр, бохир усны төлбөр хамаарахгүй. Үүнд:

- шугам сүлжээний угаалга, дүүргэлт;
- хэрэглэгчийн зохисгүй үйл ажиллагаанаас үүссэн усны алдагдал /хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтэл г.м/;
- хангагч, хэрэглэгчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, сантехникийн тоноглолын зүй бус алдагдал;
- усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар ашиглах.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудаас үзүүлэх дор дурдсан төлбөрт үйлчилгээний төлбөр нь төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөрт хамаарахгүй. Үүнд:

- төлбөрт засвар, үйлчилгээ;
- усны тоолуур баталгаажуулалт;
- цэвэр, бохир усны лабораторын шинжилгээ;
- цэвэр, бохир усны хуримтлагдсан өр төлбөр.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь онцгой нөхцөл байдалд тохируулж, үйл ажиллагааны горим, аюулгүй байдлыг хангах заавар мөрдүүлж ажиллана.

3.2. Шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн техникийн хүчин чадал, даралтын түвшин, хэрэглээний өөрчлөлтөд 24 цагийн турш хяналт тавьж, холбогдох техник зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллана.

3.3. Хэрэглээний өсөлтөөс шалтгаалан шугам сүлжээ, насос станцын ачаалал зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс хэрэглэгчийн ус хангамжийг хязгаарлах арга хэмжээ авч болно.

3.4. Хэрэглэгчийн эзэмшлийн шугам сүлжээнд усны зохисгүй хэрэглээ, зүй бус алдагдал байгаа эсэхийг тодруулах зорилгоор хангагч байгууллагаас үзлэг, шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авна.

3.5. Хангагч нь тоолуурын заалтыг цаг тухайд нь үнэн зөв бүртгэж, баталгаажуулан, хэрэглэгчдэд усыг зүй зохистой, хэмнэлттэй хэрэглэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллана.

3.6. Хэрэглэгчдийн дуудлага, гомдол, хүсэлтийг хүлээн авч, түргэн шуурхай барагдуулна. Шаардлагатай тохиолдолд төлбөрт үйлчилгээний журмын дагуу засвар үйлчилгээ хийнэ.

3.7. Ус түгээх байр хариуцан ажилладаг тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ журмын 2.1-д заасан хугацаанд ухаалаг ус түгээх байрны карт дахь усны тарифыг тэглэнэ.

3.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сумын төв, суурин газрын худаг, ус түгээх байр зэрэг төвлөрсөн бус ус хангамжийн ашиглалт, үйлчилгээг хариуцаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, үйлчилгээг хэвийн явуулахад шаардлагатай мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж, тайлан мэдээ авч хамтран ажиллана.

Дөрөв. Хэрэглэгчийн эрх, үүрэг

4.1 Хэрэглэгч нь цэвэр усыг зүй зохистой, хэмнэлттэй хэрэглэх, өөрийн шугам, тоног төхөөрөмжийн ашиглалтын хэвийн байдлыг хангана.

4.2 Хэрэглэгч нь стандартын шаардлага хангасан хэмжих хэрэгсэлтэй байна.

4.3 Хэрэглэгч нь энэхүү түр журам мөрдөгдөх хугацаанд мэргэжлийн байгууллагын шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.4. Хэрэглэгч нь хангагч байгууллагад тоолуурын заалтыг цаг тухайд нь үнэн зөв мэдээлж, баталгаажуулна.

4.5. Төрөөс усны төлбөрийг чөлөөлж буй энэ хугацаанд өмнө нь хуримтлагдсан өр төлбөртэй хэрэглэгчид төлбөрөө 2021 оны 1 дүгээр улиралд багтаан барагдуулах арга хэмжээ авч ажиллах бөгөөд өр төлбөрөө барагдуулсан тохиолдолд цаашид төрөөс хариуцах төлбөрт бүрэн хамрагдана.

Тав.Хяналт, хариуцлага

5.1. Усны зүй бус хэрэглээ, алдагдал зэргээс учрах хохирлыг гэм буруутай тал бүрэн хариуцаж барагдуулна.

5.2. Хэрэглэгч нь төрөөс хариуцах төлбөрийн дүнг үндэслэлгүй буруу мэдээлсэн, хуурамч баримт бүрдүүлсэн тохиолдолд түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---

ТӨРӨӨС ХАРИУЦАХ ЦЭВЭР, БОХИР УСНЫ ТӨЛБӨР ТООЦООГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дүгээр тогтоолын дагуу айл өрхийн болон зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах /цаашид "төрөөс хариуцах төлбөр" гэх/-тай холбогдон гарах төлбөр, тооцооны үйл ажиллагааг энэ түр журмаар зохицуулна.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1-д заасан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд төрөөс хариуцаж төлөхтэй холбоотой харилцаанд энэхүү журмыг мөрдөнө.

2.2. Төрөөс хариуцах төлбөрт цэвэр, бохир усны төлбөр, усны суурь тариф /хураамж/, гэр хорооллын ус түгээх байрнаас борлуулах болон зөөврөөр хүргэх усны төлбөр, тусгай зөвшөөрөлтэйгээр зориулалтын тээврийн хэрэгслээр бохир ус татан зайлуулах төлбөрүүд хамаарна.

Тайлбар: "зөөврөөр хүргэх ус" гэдэгт гэр хороололд зөөврөөр түгээх ундны усыг ойлгоно.

2.3. Шинээр нэмэгдэх хэрэглэгчийн төлбөрийг ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага /цаашид "тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх/-тай хийсэн гэрээг үндэслэн тооцно.

2.5. Төрөөс хариуцах төлбөрт дор дурдсан цэвэр, бохир усны төлбөр нь хамаарахгүй. Үүнд:

- шугам сүлжээний угаалга, дүүргэлт;
- хэрэглэгчийн зохисгүй үйл ажиллагаанаас үүссэн усны алдагдал /хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл г.м/;
- хангагч, хэрэглэгчийн шугам сүлжээний зүй бус алдагдал;
- усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар ашиглах асуудал.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үзүүлэх дор дурдсан төлбөрт үйлчилгээний төлбөр нь төрөөс хариуцах төлбөрт хамаарахгүй. Үүнд:

- төлбөрт засвар үйлчилгээ;
- усны тоолуур баталгаажуулалт;
- цэвэр, бохир усны лабораторын шинжилгээ;
- цэвэр, бохир усны хуримтлагдсан өр төлбөр

Гурав. Төрөөс хариуцах төлбөрийг тооцох

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалт, үйлчилгээг нь хариуцаж ажилладаг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн ус, татан зайлуулсан бохир усны төлбөрийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (цаашид “Зохицуулах зөвлөл” гэх)-өөс баталсан хэрэглэгчийн тарифын ангилалт тус бүрээр тооцно.

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалт, үйлчилгээг нь хариуцаж ажилладаг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн ус, татан зайлуулсан бохир усны төлбөрийн 2019 оны 12 дугаар сарын гүйцэтгэл, 2020 оны 1-6 дугаар сарын гүйцэтгэлийг энэхүү журмын хавсралтад заасан хүснэгтийн дагуу гаргаж, баталгаажуулан 2020 оны 12 дугаар сарын 30-ны дотор Зохицуулах зөвлөлд ирүүлнэ.

3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд ашиглалт, үйлчилгээг нь хариуцаж ажилладаг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн ус, татан зайлуулсан бохир усны төлбөрийн сар бүрийн гүйцэтгэлийн тооцоог дараа сарын 5-ны өдрийн дотор энэхүү журмын хавсралтад заасан хүснэгтийн дагуу гаргаж, баталгаажуулан, холбогдох баримтын хамт Зохицуулах зөвлөлд ирүүлнэ.

3.4. Сумын төв, суурин газруудын худаг, ус түгээх байр зэрэг төвлөрсөн бус ус хангамжийн усны төлбөрийн тухайд тухайн аймгийн төвийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний үндсэн дээр хариуцан ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагаас тооцоог энэхүү журмын хавсралтад заасан хүснэгтийн дагуу нэгтгэн гаргаж, холбогдох баримтын хамт дараахь журмаар Зохицуулах зөвлөлд ирүүлнэ. Үүнд:

- төлбөрийг тухайн суманд батлагдсан тарифаар, хэрэв тариф нь Монгол Улсын хууль зүйн актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй бол тухайн аймгийн төвийн ус түгээх байрны тарифаар тооцно.
- 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, сар бүрийн төлбөрийн гүйцэтгэлийн тооцоог дараа сарын 08-ны өдрийн дотор

3.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээгээр ажилладаг ус түгээгчдийн тооцоог энэхүү журмын 3.3 дахь заалтад заасны дагуу тооцно.

3.6. Төрөөс хариуцах төлбөрийг тооцох цэвэр, бохир усны хэмжээг одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, аргачлалын дагуу дараах байдлаар тооцно. Үүнд:

- хэрэглэгчийн усны хэмжээг Монгол Улсын стандартад нийцсэн, эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тоолуурын заалтаар, тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т зааснаар байгаль орчин, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэрэглээний жишиг, нормыг үндэслэн
- ус түгээх байрны түгээсэн усны хэмжээг тоолуур тоолуургүй тохиолдолд усан сангийн дүүргэлт, насосны ажилласан цагийн аль нэгийг үндэслэн;
- зөөврийн бохир усны хэмжээг цэвэрлэх байгууламж хариуцсан тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хийсэн гэрээний гүйцэтгэлээр.

3.7.Хэрэглэгчийн цэвэр, бохир усны хэрэглээг Засгийн газрын 211 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг үндэслэн өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй жишиж тооцно.

3.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн гүйцэтгэлийн дүн нь Зохицуулах зөвлөлд ирүүлсэн орлогын төлөвлөгөө болон эрх бүхий байгууллагаас баталсан хязгаараас хэтрэхээргүй байна.

3.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь төрөөс цэвэр, бохир усны төлбөрийг чөлөөлж буй энэ хугацаанд өмнө нь хуримтлагдсан өр төлбөрөө барагдуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллана.

Дөрөв. Цэвэр, бохир усны төлбөрийг тооцох, тооцоог хянан баталгаажуулах

4.1.Зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 6 дугаар сарын гүйцэтгэлийг энэхүү журамд заасны дагуу хянаж, тооцоог Барилга, хот байгуулалтын яаманд ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.

4.2.Барилга, хот байгуулалтын яам ажлын 2 өдрийн дотор хянаж, баталгаажуулан, нэхэмжлэхийн хамт Сангийн яаманд хүргүүлнэ

Тав. Цэвэр, бохир усны төлбөрийн тооцоог хийх

5.1. Зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй төлбөр тооцоо хийх эрх бүхий байгууллага байна

5.2. Зохицуулах зөвлөл нь арилжааны банкинд Барилга, хот байгуулалтын яамнаас цэвэр, бохир усны төлбөр хүлээн авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд уг төлбөрийг хийх зориулалт бүхий түр данс нээнэ.

5.3. Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн төлбөрийн гүйцэтгэлийн тооцоо, нэхэмжлэхийг Сангийн яам хянан үзэж, шаардлагатай санхүүжилтийг Барилга, хот байгуулалтын яамны дансанд шилжүүлнэ.

5.4. Сангийн яамнаас шилжүүлсэн санхүүжилтийг Барилга, хот байгуулалтын яам дансанд орсноос хойш ажлын 1 өдрийн дотор Зохицуулах зөвлөлийн түр дансанд шилжүүлнэ.

5.5. Зохицуулах зөвлөл түр дансанд санхүүжилт хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дансанд шилжүүлнэ.

5.6. Сангийн яамнаас Барилга, хот байгуулалтын яаманд шилжүүлсэн төлбөр нь нэхэмжилсэн дүнгээс бага байх тохиолдолд Зохицуулах зөвлөл нь баталгаажсан дүнд үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хувь тэнцүүлсэн байдлаар төлбөр тооцоог хийнэ.

5.7. Зохицуулах зөвлөл Барилга, хот байгуулалтын яаманд төлбөр шилжүүлсэн тухай тайлан, мэдээг дараа сарын 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1. Энэ журамд заасан хугацаанд багтаж төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөрийн мэдээллийг ирүүлээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тооцоог дараа сар хүртэл хойшлуулах бөгөөд үүнтэй холбогдож гарах үр дагаврыг тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төрөөс хариуцах төлбөрийг үндэслэлгүй буруу тооцсон, мэдээллийг хуурамчаар гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.3. Зохицуулах зөвлөл нь энэхүү журам хэрэгжих хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн холбогдох хэрэглэгчийн тарифыг нэмэгдүүлэхгүй.

--- о О о ---

Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог
зохицуулах түр журмын хавсралт

Хүснэгт 1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цэвэр бохир усны төлбөрийн судалгаа

Аймаг, нийслэл: _____

Сум, дүүрэг: _____

ТЗЭ-ийн нэр: _____

Регистр: _____

Хугацаа: _____

Үйлчилгээний төрөл				Тариф НӨАТ-тай /төл/м3/	Хэрэгсэл чин 100	Усны хэрэглээ мян.м³	Төлбөрийн дүн
Цэвэр ус	Төвлөрсөн	Айл өрх	Тоолуургай				
			Тоолуургүй				
		ААНБ-н хэрэглэгч	Доор дурьдсанаас бусад үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага				
			Тусгай зөвшөөрөл эзэмшигч				
			Ус, ундааны үйлдвэр, машин угаалга				
			Ноос ноолуур, арьс шир, өлөн гадас боловсруулах үйлдвэр				
		Хөнгөлөг- дохгүй	Төсөв				
			Төрийн болон орон нутгийн өмчит түүний оролцоотой хуулитын этгээд				
			Бусад				
		Айл өрх	УТБ				
Бохир ус	Төвлөрсөн	ААНБ	Зөөвөр				
	Төвлөрсөн	Айл өрх	Тоолуургай				
			Тоолуургүй				
		ААНБ-н хэрэглэгч	Доор дурьдсанаас бусад үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага				
			Тусгай зөвшөөрөл эзэмшигч				
			Ус, ундааны үйлдвэр, машин угаалга				
			Ноос ноолуур, арьс шир, өлөн гадас боловсруулах үйлдвэр				
		Хөнгөлөг- дохгүй	Төсөв				
			Төрийн болон орон нутгийн өмчит түүний оролцоотой хуулитын этгээд				
			Бусад				
Суурь хураамж	Төвлөрсөн	Айл өрх	Зөөвөр				
	Төвлөрсөн	ААНБ	Зөөвөр				
	Төвлөрсөн	ААНБ	Хөнгөлөгдох	ф15			
			Хөнгөлөгдох	ф20			
			Хөнгөлөгдох	ф25			
			Хөнгөлөгдох	ф32			
			Хөнгөлөгдох	ф40			
			Хөнгөлөгдох	ф50			

Үйлчилгээний төрөл				Тариф НӨАТ-тай /төг/м3/	Хэрэглэг- чийн тоо	Усны хэрэглээ мян.м³	Төлбөрийн дүн
			φ65				
			φ80				
			φ100				
			φ125				
			φ150				
			φ200				
			φ250				
			φ300				
			φ400, -с дээш				
		Хөнгөлөг дохгүй					

Дарга

/

/

Ерөнхий нягтлан бодогч

/

/

Эдийн засагч

/

/